



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 457,200,000.00 (дөрвөн зуун тавин долоон сая хоёр зуун мянган) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобааз, аймаг, нийслэл дэх цагдаагийн газар болон Хил хамгаалах ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Баянхонгор, Баян-Өлгий, Хэнтий, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

132003034

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны ... дүгээр сарын ... -ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА АВТОБААЗ, АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗАР БОЛОН
 ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	УАЗ-220695-550 фургон, 51-20 УЕВ, (xtt220695n1210350)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	ЦЕГ-ын харьяа Автобааз
2	УАЗ-220695-550 фургон, 92-80 УНМ, (xtt220695n1209209)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	ЦЕГ-ын харьяа Автобааз
3	УАЗ-220695-550 фургон, 32-67 СУУ (htt220695n1210347)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газар
4	УАЗ-220695-550 фургон (htt220695n1210349)	2022	ш	1	45,900,000.00	45,900,000.00	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар
5	УАЗ-220695-550 фургон 01-09 ХӨН (htt220695n1210337)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар

6	УАЗ-220695-550 фургон (htt220695n1210346)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар
7	УАЗ-220695-550 фургон (htt220695n1208315)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар
8	УАЗ-220695-550 фургон (htt220695n12336)	2022	ш	1	52,200,000.00	52,200,000.00	
9	УАЗ-220695-550 фургон (htt220695n1209201)	2022	ш	1	45,900,000.00	45,900,000.00	Хил хамгаалах ерөнхий газар
	Нийт дүн					457,200,000.00 (дөрвөн зуун тавин долоон сая хоёр зуун мянган)	